



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/291

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 17.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах, "Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр III" хэрэгжүүлэх зорилгоор "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2026" арга хэмжээг зохион байгуулах зардалд нэмэлт хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

